

CASE STUDY АРГА НЬ МЭРГЭЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГАД БАРИМЖААЛСАН СУРГАЛТЫН ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОЛОГИ БОЛОХ НЬ

Д.Дунгаамаа
ШУТИС ДаТСургууль
dungaamaa@stda.edu.mn

Хураангуй

Энэхүү судалгааныхаа үр дүнд заах арга зүйн систем, хэв маягийг зайлшгүй өөрчлөх хэрэгтэй болохыг баримтаар нотолж, орчин үеийн дээд боловсрол дахь эдгээр асуудлыг шийдвэрлэх шинэлэг сургалтын идэвхтэй арга болох Case study аргыг хэрэглэхийг санал болгосон болно.

Түлхүүр үг: Боловсролын инновац, идэвхтэй сургалтын арга, Case study арга

Оршил:

Өнөөгийн нийгмийн хөгжлийн хандлага, тухайлбал мэдээллийн технологийн эрчимтэй хөгжил, нийгмийн амьдралын хүрээнүүд болон хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт зэргийг мэдэрч ойлгож байгаа ажил олгогчид зөвхөн хариуцлагатай, гүйцэтгэгч ажилтныг бус өөрийн ажлыг сайн мэддэг, дасан зохицох болон тодорхой бус нөхцөл байдалд ажиллах чадвар сайтай, байнга өөрийгөө хөгжүүлдэг, бие дааж хариуцлагатай шийдвэрийг гаргаж чаддаг тийм мэргэжилтэнг хүсэж байна.

Ийм бодит нөхцөл шалтгааны улмаас дээд боловсролын системд шинэчлэл хийгдэж байна. Орчин үеийн багшийн гол зорилго нь суралцагчдад мэдлэгийг дамжуулах бус, харин бие дааж суралцах чадварт сургах, мэргэжлийн хандлага, чиг баримжаа олгох, шаардлагатай мэдээллийг бие дааж хайх, түүнтэй ажиллах чадварыг төлөвшүүлэх өөрөөр хэлбэл суралцагчдын танин мэдэх бүтээлч идэвхийг өдөөх, бие даан суралцахад сэдэлжүүлэх явдал болж байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд багш сургалтын арга зүйгээ шинэчлэх өөрчлөх ёстой. Сургалтын арга зүйн өөрчлөлтийн чиглэл хандлагыг дараах байдлаар тодорхойлж болох юм: мэргэжлийн чиг хандлага, өөрийгөө хөгжүүлэх тухайлбал танин мэдэхүйн чадвараа хөгжүүлэх чадвар, бие хүний төлөвшилт, хэрэгцээ, сонирхол, сэдэлжүүлэлтэнд нөлөөлөх гэх мэт. Суралцагчдад дээрх чадварыг олгоход гадаадын дээд боловсролын практикт кейс арга хамгийн үр бүтээлтэй арга гэж тооцогдож байна.

Зорилго: Сургалтын идэвхтэй аргууд нэг болох кейс аргын тухай судлах, түүнийг Монголын түүхийн хичээлд хэрэглэж үр дүнд нь дүн шинжилгээ хийх

Зорилт: Монголын түүхийн хичээлээр кейс бэлтгэн туршилт хичээл орох, үр дүнг нь уламжлалт хичээлийн үр дүнтэй харьцуулах, дүгнэлт хийх

Арга: Дүн шинжилгээний арга, цуглуулсан мэдээлэлд анализ хийх, харьцуулах арга, туршилтын арга

Судалгааны үр дүн:

Case study буюу тодорхой нөхцөл байдлыг (кейсийг) судалж дүгнэлт хийх арга нь ямар нэг асуудалтай нөхцөл байдлыг шийдвэрлэх явдалд үндэслэсэн асуудал шийдвэрлэх сургалтын идэвхтэй арга. Энэ аргын гол санаа нь:

1. Кейс аргын технологи нь бодит амьдралд болсон олгох ёстой мэдлэг практик дадлыг агуулсан тохиолдлын загварыг тодорхой журмаар боловсруулна. Ингэхдээ багш асуулт тавих замаар хэлэлцүүлэг өрнүүлэн шийдлүүдийг тэмдэглэн тодотгож мэдлэг бүтээх процесст чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

2. Сургалтын гол акценти нь бэлэн мэдлэгийг дамжуулах явдал биш харин түүнийг багш оюутан хамтарч мэдлэг бүтээхэд оршино.

3. Энэ аргыг хэрэглэсний үр дүнд оюутнууд мэдлэг олж авах төдийгүй үнэт зүйлийн систем, мэргэжлийн үйл ажиллагааны дадалтай болно.

4. Энэ арга нь уламжлалт сургалтын сул тал болох мэдлэгийг шууд дамжуулдаг байдлыг халж, сэтгэл хөдлөл бүхий бүтээлч өрсөлдөөнийг бий болгодог.

Энэ сургалтын арга улам бүр оюутнуудын дэмжлэгийг олж, сурах хандлага сонирхлыг нэмэгдүүлж байна. Үүний зэрэгцээ кейс арга нь багшийн хувьд шинээр сэтгэх үйл ажиллагаа явуулах бүтээлчээр сэтгэх хэлбэр болдог байна.

Сургалтанд ашиглах кейс нь бодит амьдралаас авсан зүгээр нэг үйл явдлын үнэн тэмдэглэл биш нөхцөл байдлыг ойлгох боломж олгодог мэдээллийн цогц юм.

Оросын судлаач А. Долгоруков сургалтын зорилгоор нь кейс -ийг

1. Анализ хийх, үнэлэлт гаргахад сургах кейс
2. Асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргахад сургах кейс

3. Асуудал, шийдвэр эсвэл үзэл хандлагыг бүхэлд нь тайлбарлах кейс хэмээн ангилсан.

Кейс олон янзын хэлбэртэй байж болно. Хэдэн өгүүлбэрээс эхлээд олон хуудастай байж болно.

Кейс хийх тодорхой стандарт байхгүй. Ихэвчлэн кейс нь хэвлэмэл буюу электрон хэлбэртэй байна. Кейсийн текстэнд зураг, диаграмм, таблицыг оруулж өгвөл илүү оюутанд ойлгомжтой болно. Мөн аудио буюу видео хэлбэртэй байж болно. Сүүлийн жилүүдэд мультимедиа кейсүүдийг өргөнөөр хэрэглэх болжээ.

Кейс аргыг сургалтанд ашиглахад судлаачид дараах үе шатыг ялган үзэж байна.

- Оюутнуудыг кейстэй танилцуулах
- Кейст дүн шинжилгээ /дүгнэлт/ хийх
- Кейсийн хэлэлцүүлэг маргаан, презентаци зохион байгуулах
- Хэлэлцүүлэгт оролцогчдыг үнэлэх, дүгнэх
- Хэлэлцүүлэгийн дүн гаргах, дүгнэлт хийх

Кейсийн хэлэлцүүлгийг зохион байгуулна гэдэг нь оюутнуудад асуулт тавьж, үүний үндсэн дээр хэлэлцүүлгийг өрнүүлнэ гэсэн үг. Ихэвчлэн кейсийн асуултуудыг багш урьдчилан бэлтгэж, кейсийн тексттэй хамт оюутнуудад санал болгоно. Ихэвчлэн хоёр аргаар явуулна.

1. Нээлттэй хэлэлцүүлэг

2. Багаар ажиллан, амаар нөхцөл байдлын анализ хийж өөрсдийн дүгнэлт шийдвэр зөвлөмжийг тайлбарлана.

Хэлэлцүүлэг кейс технологид гол байр суурь эзэлдэг. Бие дааж сэтгэх өөрийн үзэл бодлыг баримтжуулах, батлах, үндэслэх, зөв ойлгомжтой илэрхийлэх дадалтай болно. Хэлэлцүүлгийн явцад багш оюутан бүрийг оролцуулах, баримт нотолгоо тайлбарыг сонсох, хэлэлцүүлгийг удирдан чиглүүлэх хэлэлцүүлэгийн дүн гаргах, дүгнэлт хийх үүрэг гүйцэтгэнэ.

Бид ч гэсэн энэ аргыг судалж түүнийг сургалтанд хэрэглэх арга барил эзэмших хэрэгтэй болж байна. Энэ нь ирээдүйн шинэ мэргэжилтэнд тавигдаж буй шаардлагаас урган гарч байна.

Үүний тулд Монголын түүх хичээлд кейс аргыг хэрэглэсэн туршилт хичээл зохион явуулж, түүний үр дүн тооцох судалгаа хийлээ. Судалгаанд ДаТС-ийн 1 курсийн Монголын түүх судалж байгаа 2 группийн оюутнууд хамрагдсан. Нэг группийг нь туршилтийн групп болгон кейс аргаар, нөгөө группэд нь уламжлалт аргаар хичээлээ зохион байгуулж дараах сэдвээр хичээл заалаа.

1. Монгол манжийн эрхшээлд орсон нь

2. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсал, түүний ач холбогдол

Туршилтын группэд хичээлээ заахын тулд юуны өмнө дээрх сэдвээр цаасан болон аудио кейс, түүхэн үйл явдлын шалтгаан үр дагаврыг тодруулах, хэлэлцүүлэг явуулах кейсийн асуулт, даалгавар болон тухайн хичээлийн үр дүнг тооцох тестийг бэлдсэн.

Хичээлийн явцад

- Кейс буюу бодит жишээ баримтыг уншиж танилцах

- Хэд хэдэн удаа уншиж эрэгцүүлэх


- Гол үйл явдал, түүний учир шалтгаан, үр дагаврыг өгөгдсөн асуулт, даалгаврын дагуу бичиж тэмдэглэх

- Энэ үндсэн дээр тухайн сэдвээр түүхч Д. Өлзийбаатарын боловсруулсан аудио кейс сонсонг харьцуулах, тодруулах боломж олгох

- Бэлтгэсэн асуултаар хэлэлцүүлэг өрнүүлэх, хэлэлцүүлгийн явцад өөрийн санааг тайлбарлан ярих, түүнийгээ баримтаар баяжуулах боломж олгон, төгсгөлд хамтарч дүгнэлт хийлээ.

- Хичээлийн төгсгөлд олж авсан мэдлэгийг шалгах 13-15 асуулт бүхий сорилыг ажиллууллаа.

“Монгол манжийн эрхшээлд орсон нь” сэдэвт хичээлийн шалгалтын тестийг харьцуулсан байдал



“1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсал, түүний ач холбогдол” сэдэвт хичээлийн шалгалтын үр дүнг харьцуулсан байдал

Тестийн шалгалтын чанарын харьцуулсан график



Уламжлалт болон кейс аргаар зохион явуулсан хичээлийн үр дүнгүүдийг харцуулсан графикаас үзвэл сургалтын чанар болон үр дүнд багшийн сургалтын арга ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Кейс дээр ажиллах чадвар хангалттай сайн биш байсан ч оюутнууд учир шалтгааныг ойлгох, өөрийнхөөрөө тайлбарлахыг хичээж энэ нь зөв, энэ нь буруу гэсэн хэмжүүр, үнэлэмжтэй болж байгаа нь ажиглагдлаа.

Дүгнэлт:

1. Монголын түүхийн хичээлд кейс аргыг хэрэглэн зохион байгуулсан хичээлийн амжилт нь уламжлалт хичээлийн амжилтаас даруй 18%-10% илүү байгаа нь сургалтын чанарыг сайжруулах ач холбогдолтой байна.

2. Кейс арга нь оюутнуудын сурах хандлага, сонирхолыг нэмэгдүүлэх улмаар өөрийгөө илэрхийлэх, бусад хүмүүстэй зөв харилцах, оюутнуудыг бие дааж сэтгэх, дүгнэлт хийх, асуудал шийдвэрлэх чадвартай болоход ихээхэн үр дүнтэй болох нь харагдлаа. Ингэснээр ажил олгогч нарын ирээдүйн мэргэжилтнээс хүсч байгаа сэтгэн бодох дадал чадвар, мэргэжлийн чадамж төлөвшүүлэх боломжтой болно.

3. Хэдийгээр кейс аргыг анх бизнесийн боловсролд хэрэглэж эхэлсэн боловч түүнийг нийгмийн, хүмүүнлэгийн, техникийн ухааны хичээлүүдэд хэрэглэх боломжтой төдийгүй зайлшгүй шаардлагатай байна.

Зохиогчийн тухай: Д.Дунгаамаа-ОХУ-ын Эрхүү хотын улсын их сургуулийг 1990 онд түүхч, түүхийн багш мэргэжлээр төгссөн. Магистр, МУБИС-ын докторант. Судалгааны чиглэл-Монголын түүх судлал

Ашигласан ном, хэвлэл:

1. Сафина. А.А. Возможности применения кейс метода в процессе обучения студентов технических вузов.

2. Ситуационный анализ, или Анатомия Кейс метода. // под. ред. Ю.П.Сурмиха.- Киев. Центр инноваций и развития, 2002, -286 с.

3. Долгоруков. А. Метод case- study как современная технология-ориентированного обучения.// http://www.vshu.ru.lections.php.tab_id=3&a=info&id=2600//

4. Михайлова, Е.Н.Кейс и Кейс-метод: общие понятия. //Маркетинг. -1999. - №1//

5. Андюсев. Б.Е. Кейс метод как инструмент формирования компетентностей. // Директор школы. -№4, -2010,- 61-69с //